



**ЗАВХАН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

81090 Улиастай, Завхан аймаг
Утас/Факс: 7046-36-12
И-мэйл: zavkhan@audit.gov.mn

**ОРОН НУТГИЙН ХУРЛЫН
ЭЭЛЖИТ СОНГУУЛЬД ОРОЛЦОХ
АРДЧИЛСАН НАМ-Д**

2024.08.09

№

449

танай

-ны №

-т

Сонгуулийн мөрийн хөтөлбөр
хуульд заасан шаардлагад
нийцсэн талаарх дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйл, Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.5, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5.4-т заасан Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд 2024 оны Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуульд оролцохоор ирүүлсэн "Ардчилсан нам"-ын сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянаж, дүгнэлт гаргалаа.

Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл

Орон нутгийн Хурлын 2024 оны сонгуульд оролцох нам, эвсэл болон бие даан нэр дэвшигч нь сонгуулийн мөрийн хөтөлбөрөө Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, УИХ-аас баталсан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт нийцүүлэн боловсруулж, санхүүгийн тодорхой эх үүсвэр шаардсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын талаарх тооцоо, судалгааг гарган хуульд заасны дагуу дүгнэлт гаргуулах үүрэг хүлээнэ.

Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага нь 2024 оны Орон нутгийн Хурлын ээлжит сонгуульд оролцох нам, эвсэл болон бие даан нэр дэвшигчийн сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянан үзэхдээ Төрийн аудит MNS 6817 - 1 : 2020 Төрийн аудит. Тулгуур зарчим, MNS 6817 - 6 : 2020 Төрийн аудит. Нийцлийн аудитын зарчим, MNS 6817 - 8 : 2020 Төрийн аудит. Нийцлийн аудит стандартыг удирдлага болгон Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, УИХ-аас баталсан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичиг, Монгол Улсын нэгдсэн төсвийн 2024 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2025-2026 оны төсвийн төсөөллийн тухай хууль, холбогдох байгууллагаас авсан тайлан, судалгаа, мэдээллийг тус тус шалгуур болгон авч үзсэн.

98101058

Дүгнэлт

“Ардчилсан нам”-ын Орон нутгийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцохоор ирүүлсэн сонгуулийн мөрийн хөтөлбөрийн зорилт, арга хэмжээ нь Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.3 дахь хэсэг, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.3 дахь хэсэг, Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан тусгай шаардлагад тус тус нийцсэн байна.

“Ардчилсан нам”-ын мөрийн хөтөлбөр (.....⁸..... хуудас)-ийг хавсаргав.

Хувийг: Завхан аймгийн Сонгуулийн хороонд

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР



Д.БАТ-УНДРАА

ОРОН НУТГИЙН ХУРЛЫН 2024 ОНЫ ЭЭЛЖИТ СОНГУУЛЬД
ЗАВХАН АЙМГИЙН АРДЧИЛСАН НАМААС ДЭВШҮҮЛЖ
БУЙ МӨРИЙН ХӨТӨЛБӨР



ЭРЧИМТ ХӨГЖЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Улиастай хот
2024 он

**ЗАВХАН АЙМГИЙН ИТХ-ЫН СОНГУУЛЬД АРДЧИЛСАН НАМААС
ДЭВШҮҮЛЖ БУЙ “ЭРЧИМТ ХӨГЖЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ” МӨРИЙН ХӨТӨЛБӨР**

НЭГ. ХҮНИЙ ХӨГЖИЛ - НИЙГМИЙН БОДЛОГО

1.1 ЭРҮҮЛ МЭНДИЙН ЧИГЛЭЛЭЭР


1.1.1 Орон нутгийн эмч, эмнэлгийн ажилтнуудын хүрэлцээ хангамж ур чадварыг сайжруулан, эмчилгээ оношилгооны дэвшилтэд технологи, арга барилыг нэвтрүүлэн эмнэлгийн ажилтан мэргэжилтнүүдийг тогтмол сургалтад хамруулж чадавхжуулах ажлыг үе шаттайгаар зохион байгуулна.

1.1.2 Эрүүл мэндийн байгууллагын эмнэлгийн үйлчилгээг сайжруулж явуулын амбулатори, үзлэг, оношилгоог жил бүр үе шаттайгаар зохион байгуулна.

1.1.3 Хөгжлийн бэрхшээлтэй болон эмзэг бүлгийн иргэдийг эрүүл мэндийн үзлэг оношилгоо, урьдчилан сэргийлэх эмчилгээ, сувилгаанд тогтмол хамруулна.

1.1.4 Орон нутгийн онцлогт тулгуурлан эмчилгээ, сувилал, амралтын газар байгуулах хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтыг дэмжиж, уламжлалт эмнэлгийн үйлчилгээг хөгжүүлнэ.

1.1.5 Эмнэлгийн байгууллагын материаллаг баазыг бэхжүүлж, иргэдэд эмнэлгийн үйлчилгээг түргэн шуурхай хүргэх асуудлыг цогцоор нь үе шаттайгаар шийдвэрлэнэ.



**1.2 БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ ХӨГЖЛИЙГ
ДЭМЖИХ ЧИГЛЭЛЭЭР**

1.2.1 Бүх нийтийн боловсролын төвшинг дээшлүүлэн, хичээлийн байр болон дотуур байр, цэцэрлэгийн орчин нөхцөлийг сайжруулж, сургалтын материаллаг бааз, тоног төхөөрөмжөөр хангагдсан, орчин үеийн дэвшилтэт технологи бүхий сургалтын орчин бүрдүүлнэ.

1.2.2 Нийт боловсролын байгууллагын багш, сурган хүмүүжүүлэгчдийн мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэх, сургалтын шинэ дэвшилтэд арга барилуудыг нэвтрүүлэх үүднээс шинжлэх ухаан, эрдэм шинжилгээний цогц бодлогыг хэрэгжүүлэн төрөл бүрийн сургалтад хамруулж тусгайлсан хөтөлбөр хэрэгжүүлнэ.

1.2.3 Нийтийн биеийн тамирыг бүх нийтийн хүртээл болгон хүн амыг хөдөлгөөний дутагдлаас урьдчилан сэргийлэх, ажлыг эрчимжүүлж, чийрэгжүүлэх танхимыг сумын төв, байгууллагуудад зохистой хэлбэрээр бий болгон хөгжүүлж, хүн амын дундаж наслалтыг улсын дундаж түвшинд хүргэх нөхцөлийг бүрдүүлнэ.

1.2.4 Орон нутагт хөгжүүлэх боломжтой зарим нэр төрлийн спортыг бодлогын хэмжээнд дэмжиж аймаг, улс бүсийн аваргыг сум орон нутгуудаас төрүүлэх арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.

1.2.5 Хүүхэд залуучуудыг үндэсний спортоор хичээллэх нөхцөлийг бүрдүүлэн, амжилт гаргасан тамирчдыг дэмжиж, үндэсний спортын холбоодтой хамтран ажиллана.

1.2.6 Насан туршийн боловсролын хүртээмж, чанар, үр өгөөжийг дээшлүүлнэ.

1.2.7 Соёлын биет болон биет бус өвийг хадгалах, өвлүүлэх олны хүртээл болгох чиглэлээр хийгдсэн ажлуудыг бататгаж, бүртгэлжүүлэх, томоохон хэмжээний зан заншил соёлын өв тээгчдийг илрүүлэн урамшуулж баталгаажуулна.

1.2.8 Нийгмийн эмзэг бүлэг хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн асуудлыг шийдвэрлэх цогц бодлогыг хэрэгжүүлнэ.

1.2 НИЙГМИЙН ХАМГААЛАЛ, ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙГ ДЭМЖИХ ЧИГЛЭЛЭЭР

1.3.1 Эдийн засгийн өсөлт, хөрөнгө оруулалтын арга хэмжээтэй уялдуулан ажлын байрыг тууштай нэмэгдүүлж, ажилгүйдлийн төвшинг багасган, өрхийн амьжиргааг дээшлүүлнэ.

1.3.2 Ажлын байр шинээр бий болгож буй аж ахуйн нэгж, байгууллагыг бүх түвшинд орон нутгийн бодлогоор дэмжинэ.

1.3.3 Байгаль орчныг хамгаалах, бүтээн байгуулалт, нийтийн эзэмшлийн зам талбай, ногоон байгууламжийн тохижилт үйлчилгээний ажилд амьжиргааны баталгаажих төвшингээс доогуур орлоготой иргэдийг өргөнөөр татан оролцуулах замаар өрхийн орлогыг нэмэгдүүлнэ.

1.3.4 Малчдын нийгмийн хамгааллын талаар шинэ санаачилга гаргаж, залуу малчдыг бүх талаар дэмжинэ.

1.3.5 Бүх шатны төсвийн байгууллагын ажилчдыг урамшуулах шинэ санал санаачилгыг дэмжиж, сайн туршлагыг үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ.

1.3 ХҮҮХЭД, ЗАЛУУЧУУД, АХМАД, ЭМЭГТЭЙЧҮҮДИЙГ ДЭМЖИХ ЧИГЛЭЛЭЭР

1.4.1 Хүүхэд, залуучуудын хэрэгцээ шаардлагад суурилсан, сурч боловсрох, хөгжих, соёл хүмүүжил, хөдөлмөр эрхлэлтийг дэмжсэн хөтөлбөрүүдийг хэрэгжүүлнэ.

1.4.2 хүүхэд, залуучууд, ахмад настан, эмэгтэйчүүд, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд чиглэсэн Олон улсын байгууллагуудын төсөл хөтөлбөрүүдийг орон нутагтаа татан хэрэгжүүлнэ.

1.4.3 Нийгмийн хамгааллын хуульд заасны дагуу ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан санг ил тод нээлттэй болгож нийгмийн хамгааллын арга хэмжээг хэрэгжүүлнэ.

ХОЁР. ЭДИЙН ЗАСГИЙН ТОГТВОРТОЙ ӨСӨЛТИЙГ ХАНГАХ БОДЛОГО

2.1 МАЛ, АЖ АХУЙГ ЭРЧИМЖҮҮЛЭХ ЧИГЛЭЛЭЭР

2.1.1 Мал эмнэлгийн байгууллагын үйлчилгээний чанарыг сайжруулж, малын эмч мэргэжилтнийг чадавхжуулж, мал эмнэлгийн үзлэг оношилгоо, зоо мал эмнэлгийн арга хэмжээг эрчимжүүлж, малыг аливаа өвчлөлөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээг сайжруулж, малын түүхий эд махны чанар стандартыг сайжруулахад тусгайлсан арга хэмжээ авч ажиллана.

2.1.2 Мал, малын гаралтай бүх төрлийн түүхий эд, бүтээгдэхүүний үнэ цэнийг нэмэгдүүлж, эдийн засгийн эргэлтийг хурдасгах, Орон нутгийн эдийн засгийг тэлэх бодлогыг баримлах замаар малчдын амьжиргаа, орлогыг дээшлүүлэх нөхцөл бүрдүүлнэ.

2.1.3 Мал аж ахуйг эрсдэлээс хамгаал цогц бодлогыг хэрэгжүүлнэ.

2.1.4 Бэлчээр хамгаалах дэд хөтөлбөрүүдийг боловсруулан хэрэгжүүлнэ.

2.1.5 Малын сүргийн бүтцийг чанаржуулах хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.

2.1.6 Малчдаа дэмжих орон нутгийн дэд хөтөлбөрийг хэрэгжүүлж, ахмад үеийн улс, аймаг, сумын сайн малчдын туршлага, мал маллах арга ухааныг залуу малчдад эзэмшүүлэх ажлыг зохион байгуулж, хариуцлагатай, чинээлэг малчин хөтөлбөр хэрэгжүүлнэ.

2.2 ГАЗАР ТАРИАЛАН ЭРХЛЭЛТИЙГ НЭМЭГДҮҮЛЭХ ЧИГЛЭЛЭЭР

2.2.1 Газар тариалангийн бүс нутгийг шинэчлэн тогтоож орон нутагтаа малын тэжээлийн ургамал, хүнсний ногооны тариалалтыг нэмэгдүүлж орон нутгийн иргэд аж ахуйн нэгжийн хэрэгжээг хангах бодлогыг хэрэгжүүлж ажиллана.

2.2.2 Тариалангийн үйлдвэрлэлийг нэмэгдүүлэн техник, технологийн хангамжийг сайжруулж, хүнсний ногоо хадгалах зоорийг нэмэгдүүлж, хүлэмжийн аж ахуй, усалгаатай тариалан эрхлэгч, жимс жимсгэнэ, хүнсний ногоо тариалагчдыг бодлогоор дэмжиж нэгжээс авах ургацын хэмжээг дээшлүүлнэ.

2.2.3 Бүх төрлийн тариалалтыг орон нутгийн бодлогоор дэмжин ажиллана.

2.2.4 Олон улсын байгууллага, дотоодын төсөл хөтөлбөрүүдийг орон нутагт татан хэрэгжүүлж, эрх тэгш оролцоог ханган ажиллана.

2.3 БИЗНЕС ЭРХЛЭГЧДИЙГ ДЭМЖИХ ЧИГЛЭЛЭЭР

2.3.1 Бизнес эрхлэгчдийн үйл ажиллагааг дэмжин эдийн засгийн таатай орчин бүрдүүлж, төрийн байгууллагын хууль бус дарамт шахалтыг арилгана.

2.3.2 Жижиг дунд болон өрхийн үйлдвэрлэл, худалдаа, үйлчилгээ эрхлэгчдийг төсөл хөтөлбөрүүдэд хамруулж, ажлын үр өгөөж хүртээмжийг дээшлүүлнэ.

2.3.4 Жижиг, дунд болон бичил үйлдвэрлэл эрхлэгчдийг гадаад зах зээлд гаргах, хил орчмын худалдаанд идэвхтэй оролцоход дэмжлэг үзүүлнэ.

2.3.5 Орон нутагт хэрэгжиж байгаа төсөл хөтөлбөрүүдэд тавих хяналтыг нэмэгдүүлж, хэрэгжилтийг ханган иргэдэд төсөл хөтөлбөрүүдийн талаарх мэдээллийг нээлттэй ил тод болгоно.

2.3.6 Олон улсын болон орон нутгийн төсөл хөтөлбөрүүдийн уялдаа холбоог сайжруулна.

2.4 АЖЛЫН БАЙРЫГ НЭМЭГДҮҮЛЭХ ЧИГЛЭЛЭЭР

2.4.1 Үйлдвэрлэл худалдаа эрхлэгчдийн ажиллах орчин нөхцөлийг сайжруулж, орон нутагт ажлын байр шинээр бий болгох ажил үйлчилгээг бодлогоор дэмжинэ.

2.4.2 Нөхөрлөл хоршоо, аж ахуй нэгж байгууллагуудын үйл ажиллагааг дэмжиж хамтран ажиллах замаар шинэ ажлын байрыг нэмэгдүүлнэ.

2.4.3 Орон нутагт хэрэгжих томоохон төсөл хөтөлбөрүүдийг дэмжиж хамтран ажиллах замаар ажлын байрыг нэмэгдүүлнэ.

2.4.4 Хоршоо болон жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжиж, орон нутагт хөгжлийн дэд хөтөлбөрүүдийг хэрэгжүүлнэ.

2.5 ТӨСӨВ САНХҮҮГИЙН ЧИГЛЭЛЭЭР

2.5.1 Орон нутгийн төсвийн орлогын бүрдэлт, зарцуулалтын харилцааг төрийн бодлогод уялдуулан оновчтой төлөвлөж, хэрэгжилтийг сайжруулж, эдийн засгийн хэмнэлттэй, ашигтай төсөв санхүүгийн бодлогыг хэрэгжүүлнэ.

2.5.2 Орон нутгийн өмч ашиглалт, хамгаалалтыг сайжруулна.

2.5.3 Төсвийн сахилга батыг сайжруулж, үр ашиггүй зардлыг танах, хэмнэлтийн горимд шилжүүлэх бодлого баримтална.


2.5.4 Орон нутагт хэрэгжиж байгаа сангуудын зарцуулалтыг үр дүнтэй, иргэдэд нээлттэй ил тод болгох, хөрөнгө оруулалтын ажлын гүйцэтгэл, ашиглалтад тавих хяналтыг сайжруулна.

ГУРАВ. ДЭД БҮТЦИЙН БОДЛОГО

3.1 Хэрэглэгч аймгаас үйлдвэрлэгч аймагт шилжих зорилтыг эрчимжүүлж орон нутгийн нөөц боломжид тулгуурлан үйлдвэрлэгч аймаг хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.

3.2 Аймгийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөөтэй уялдуулан шаардлагатай арга хэмжээг үе шаттайгаар авч хэрэгжүүлж ажиллана.

3.3 Аялал жуулчлалыг дагасан үйлдвэрлэл, үйлчилгээг бүх чиглэлээр хөгжүүлэх арга хэмжээ авна.



3.4 Орчин үеийн шинэлэг техник технологит тулгуурлан хот төлөвлөлт, дахин төлөвлөлтийг хийж хэрэгжилтийг зохион байгуулж, Амины орон сууц хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.

3.5 Улс, аймаг, сум хоорондын авто замын сүлжээг сайжруулж, авто зам гүүрний байгууламж барих засварлах ажлыг эрчимжүүлнэ.

3.6 Гадаадын төсөл хөтөлбөртэй хамтран ажиллах боломжийг судалж, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлнэ.

3.7 Эрчим хүчний салбарын цахилгаан, дулаан үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх үүднээс байгалийн нөөц боломжийг ашиглан усан болон нарны эрчим хүчийг нэмэгдүүлэх талаар судалгаа шинжилгээ хийж хэрэглэгчдийн цахилгаан дулааны хэрэглээний ухаалаг үнийн систем нэвтрүүлнэ.

3.8 Төсвийн хөрөнгө оруулалтыг ач холбогдлоор нь эрэмбэлэн хэрэгжилтийг зохион байгуулна.

ДӨРӨВ. БАЙГАЛЬ ОРЧИН - АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН БОДЛОГО

4.1 Онгон байгалиа хамгаалах чиглэлээр цогц бодлогыг хэрэгжүүлнэ.

4.2 Орон нутгийн онцлогт тохирсон аялал жуулчлалыг хөгжүүлнэ.

4.3 Улс болон орон нутгийн тусгай хамгаалалтыг нэмэгдүүлж, шаардлагатай арга хэмжээг үе шаттай авч хэрэгжүүлнэ.

4.4 Бэлчээрийн ургамлын сэргэх чадавхад суурилсан менежментийг боловсруулж, Цөлжилттэй тэмцэх шинэ технологи нэвтрүүлж, олон улсын хамтын ажиллагааг эрчимжүүлнэ.

4.5 Уул уурхайн лиценз нэмж олгохгүй, тоог цөөлж уул уурхайгүй аймаг болно.

4.6 Баялгийн зөв зохистой ашиглах нөхцөлийг хангаж, ашиглалт, хэрэгжилтийн явцад иргэдийн оролцоог хангана.

ТАВ. ИРГЭДИЙН ОРОЛЦОО –ЗӨВ ЗАСАГЛАЛЫН БОДЛОГО

5.1 Төрийн албаны томилгоонд шударга зарчмыг бүрэн хэрэгжүүлнэ.

5.2 Төрийн албан хаагчдыг давтан сургалтад хамруулж чадавхжуулна.

5.3 Тулгамдсан, нэн шаардлагатай зорилтуудыг олж тодорхойлох, тэдгээрийг шийдвэрт тусгаж хэрэгжүүлэх, шаардлагатай асуудлаар нээлттэй хэлэлцүүлэг зохион байгуулдаг болно.

5.4 Төрийн ажил үйлчилгээг иргэдэд нээлттэй хөнгөн шуурхай, чирэгдэл, хүндрэлгүй хүргэх бүх нөхцөл шаардлагыг аймаг, сумын түвшинд жигд хэрэгжүүлнэ.

5.5 Иргэдээ сонсох уулзалт ярилцлагыг тогтмол хийж, нээлттэй утсыг байнга ажиллуулж, санал гомдлын мөрөөр бодит ажил зохиож үр дүнг мэдэгдэж хэвшинэ.

5.6 Улаанбаатар хот болон бусад аймаг хотуудад байгаа нутгийн зөвлөлүүд, иргэний нийгмийн болон төрийн бус байгууллагуудтай харилцан хамтран ажиллаж, тэдгээрийн орон нутгаа хөгжүүлэх аливаа үйл ажиллагааг онцгойлон анхаарч дэмжиж ажиллана.

5.7 Авлигын эсрэг төрөөс баримталж байгаа бодлогыг бүх шатандаа бүрэн хэрэгжүүлж ажиллана.

5.8 Аливаа төрлийн гэмт хэргийг бууруулах төрийн бодлого шийдвэрийг бүх шатанд хэрэгжүүлж ажиллана.

5.9 Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх салбар зөвлөлийн ажлыг дэмжиж шаардлагатай арга хэмжээг тухай бүрд нь хэрэгжүүлж ажиллана.

